



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 03

Чингис хот

Төрийн байгууллагын  
үйлчилгээг сайжруулах тухай

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөэс гарсан шийдвэр болон Хэнтий аймаг байгуулагсаны 100 жилийн ойг утган төрийн байгууллагын өнгө үзэмж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн байгууллагуудад ДААЛГАХ нь:

1. Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж утгах үйлчилгээг нэвтрүүлж тогтмол хяналт тавьж ажиллах
2. Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг цаг хугацаа, орон зайнлас үл хамааран иргэд авах боломжийг судлан цахимжуулах ажлыг зохион байгуулах
3. Төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй хүргэх зорилгоор төрийн байгууллагын дотоод хурлыг Баасан гарагийн үдээс хойш зохион байгуулах
4. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын [www.khentii.mn](http://www.khentii.mn) цахим сайт болон Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын пэйс хуудсанд тавигдаж буй мэдээллийг цахимаар дамжуулан иргэдэд түгээх, байгууллагынхаа гадагш чиглэсэн мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтнуудад хүргүүлж, харилцан мэдээлэл түгээх
5. Байгууллагын гаднах авто тээврийн хэрэгслийн зогсоолд зөвхөн үйлчилгээ авч байгаа иргэдийн авто тээврийн хэрэгсэл зогсох боломжийг бүрдүүлж тогтмол хяналт тавьж ажиллах
6. Төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг (авто тээврийн хэрэгсэл гэх мэт) хувийн зорилгоор ашиглахгүй байх
7. Байгууллагын гаднах өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор барилга байгууламжийн гадна ханын хүрээгээр туузан гэрэлтүүлэг болон чиглүүлэгчтэй гэрлэн чимэглэл хийх

2.

8. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын гадна талыг зүлэгжүүлэх, моджуулах

9. Байгууллагаас гарч байгаа хог хаягдлыг ангилан ялгаж хог хаягдлын менежментийг нэвтрүүлэх

10. Байгууллага бүр хоёроос доошгүй шинэлэг ажлыг санаачлан хийж иргэд олон нийтэд сурталчлан таниулах

Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гарсан үр дүнг байгууллага тус бүрээр гарган эрэмбэлж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын орлогч Л.Батсайханд даалгасугай.

